



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/34

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 03-р сарын 10 ны өдрийн 5 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 26 ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Худалдаа үйлчилгээний газрууд шинэ төрлийн Коронавирусын тархалтаас сэргийлэх зорилготой хөл хөдөлгөөний хязгаарлалтыг мөрдөж, цэвэрлэгээ, ариутгалыг тогтмол хийж, иргэд, хэрэглэгчийг хамгаалж, урьдчилан сэргийлж байгаад хяналт шалгалт хийх "Хариуцлагатай хэрэглэгч" аяныг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Наранцэцэг /МЭТ-ийн дарга/

Гишүүдэд: Э.Цэрэнханд /Сургуулийн Нийгмийн ажилтан/

Г.Анужин /ЭМТ-ийн их эмч/


Б.Гарьдмагнай /ХААТ-ийн мэргэжилтэн/

Б.Насанжаргал /Хэсгийн цагдаа/

Хоёр: Иргэд, олон нийтийг олноор нь цуглуулахгүй, газар дээр нь тусгайлан зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллахыг Ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

Гурав: "Хариуцлагатай хэрэглэгч" аяныг иргэд олон нийтэд хүртээмжтэй, чанартай зохион байгуулж, аяны хүрээнд хийгдсэн ажлын талаарх тайлан мэдээг нэгтгэн аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэст 2020 оны 04-р сарын 10 ны дотор хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн дарга /Д.Наранцэцэг/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ЦОЛМОНБААТАР

4880100092